



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.07.29 № 689

танай _____ -ны № _____ -т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ ОРОЛЦОХ
ЖАРГАЛТХААН СУМЫН МАН-ЫН
ХОРООНЫ ДАРГА П.ЧИНБАТ ТАНАА

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд Г
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын МАН-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого,

төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын МАН-ын хорооны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын МАН-ын хорооны мөрийн хөтөлбөр (3 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР


Д.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

Д.ЭРДЭНЭБИЛЭГ

АУДИТОР

Ц.ХАТАНБОЛД





ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



2024 ОН

**ЖАРГАЛТХААН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН
ХӨТӨЛБӨР**

1. “Миний ажилтан орон сууцтай” хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчид болон ажилтандаа орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлсэн хувийн хэвшлийн ААН-үүдэд хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
2. Зорилтот бүлэг /төрийн албан хаагч, залуу гэр бүл/-д чиглэсэн орон сууцны төслийг хэрэгжүүлж, урьдчилгаа төлбөрийн батлан даалт, ипотекийн зээлийн асуудлыг шийдвэрлэнэ.
3. Жаргалтхаан сумын хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд иргэдийг хамруулна.
4. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.
5. “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг сумандаа хэрэгжүүлнэ
6. Сумын Эрүүл мэндийн төвийг стандартын шаардлага хангасан авто машин, орчин үеийн тоног төхөөрөмжүүдээр үе шаттайгаар хангана.
7. Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалттай болгоно.
8. Боловсролын бүх шатанд хөгжлийн бэршээлтэй хүүхдүүдийн сурах орчныг сайжруулж, адил тэгш боломжоор хангана.
9. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ
10. Бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хүүхдийг хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.
11. Нүүдлийн соёлын чадавхыг ерөнхий боловсролын сургалтаар өгөх, бэхжүүлэх хүрээнд биеийн тамирын хичээлийн агуулгад үндэсний бөх, технологийн хичээлд хатгамал, дээл оёх, хөгжмийн хичээлд уртын дуу, морин хуур, биелгээг оруулна.
12. Ерөнхий боловсролын сургуулийн анги танхимд ухаалаг самбартай болгоно.
13. Сургуулийн дотуур байрыг засварлах.
14. Цэцэрлэгийн хоол болон Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны стандартыг шинэчилж, орц найрлыагыг нэмэгдүүлэх, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ
15. Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3-ийг хэрэгжүүлнэ
16. Төрийн байгууллагуудын нэрэмжит Ахмадын өдөрлөгийг уламжлал болгон явуулна.
17. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх, спортын олон төрөлт тэмцээнд оролцох нөхцөл боломжийг дэмжиж ажиллана.
18. Ахмад настны хөгжлийн төвийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.
19. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана
20. Гарааны бизнес эрхлэгч оюутан, залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
21. Соёлын төвийн барилгыг шинээр барих, шаардлагатай тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлээр хангаж тохижуулна.
22. Сумын шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулж, аймаг, улсын тэмцээнд амжилттай оролцсон баг тамирчид, дасгалжуулагчийг дэмжин ажиллаж, бодлогоор дэмжинэ.
23. Малын үүлдэр угсаа хийгээд чанарыг сайжруулж, малынхаа тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах бодлогыг баримтална.



24. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг зохион байгуулж бэлчээрийн даацын нэмэгдүүлнэ.
25. "Шинэ хоршоо" хөтөлбөрийн хүрээнд малчид хоршсон байдлаар баг сумынхаа түвшинд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломжоор хангаж, дэмжлэг үзүүлнэ.
26. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх загвар хоршоодод дэмжлэг үзүүлэх
27. Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, "Монгол мал-II" арга хэмжээг сумандаа хэрэгжүүлнэ.
28. "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг сумандаа хэмжээнд өрнүүлж, хоршоолохыг дэмжинэ.
29. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сумандаа нэмэгдүүлэх бодлого баримтална.
30. Нутгийн брендийг бий болгоно.
31. Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу түр буудаллах цэгүүдийг сумандаа байгуулна.
32. Нутгийн иргэдэд түшиглэсэн, нүүдэлчин соёлыг харуулсан аялал жуулчлалыг хөгжүүлэх, чадавхижуулах, бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ.
33. Сумдын гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлнэ.
34. Сумын доторх автозамыг хатуу хучилттай болгоно.
35. Жаргалтхаанаас Өмнөдэлгэр сум хүртэлх хатуу хучилттай замыг барьж ашиглалтад оруулна
36. Жаргалтхаан-Дэлгэрхаан чиглэлийн 59.2 км хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулна
37. Эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлж, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ
38. Жил бүр 3-5 сая мод тарих замаар ойн сан, хамгаалалтын ойн зурвасыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулж "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангана.
39. Сумын гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно
40. Ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цэвэр усан хангамж, усан сангийн байгууламжийг Жаргалтхаан суманд барьж байгуулна.
41. Жаргалтхаан суманд Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийг барьж байгуулна.
42. Жишиг гудамж төслийг төвийн багт үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна
43. Сумын төв болон Багуудын цэвэр усны худгийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
44. Төр хувийн хэвшилтэй хамтран орон сууцны хотхон барьж байгуулна.

